



МОНГОЛ УЛС
ТӨВ АЙМГИЙН ЗУУНМОД СУМЫН ИРГЭДИЙН
ТӨЛӨӨЛӨГЧДИЙН ХУРЛЫН ХУРАЛДААНЫ ТОГТООЛ

2023 оны 12 сарын 19 өдөр

Дугаар 03

Зуунмод

Зуунмод сумын 2023 оны
төсөв батлах тухай

Монгол Улсын Засаг захиргаа, нутаг дэвсгэрийн нэгж, түүний удирдлагын тухай хуулийн 35 дугаар зүйлийн 35.1.9, 48.1, Төсвийн тухай хуулийн 64 дүгээр зүйлийн 64.1.2 дахь заалт, Төв аймгийн Иргэдийн Төлөөлөгчдийн Хурлын 2022 оны 12 дугаар сарын 05-ны өдрийн 02 дугаар тогтоолыг тус тус үндэслэн сумын Иргэдийн Төлөөлөгчдийн Хурлаас ТОГТООХ нь:

1. Сумын 2023 оны төсвийн орлогын нийт дүн, орлогын нэр төрлийн хэмжээг дор дурдсанаар баталсугай:

/Мянган төгрөгөөр/

Д/д	Байгууллага, орлогын нэр төрөл	Орлогын дүн /мянган төгрөг/
1.1.	Сумын төсвийн татварын орлого	5,022,728.4
1.1.1.	Үйл ажиллагааны орлого	60,000.0
1.1.2.	/Хувь хүний орлогын албан татварын тухай хуулийн 8.1.1-д заасан орлогод ногдох албан татвараас бусад хувь хүний орлогын албан татвар/ Суутган-2	175,000.0
1.1.3.	Хадгаламжийн хүүгийн орлого	364,500.0
1.1.4.	ҮХЭХ борлуулсны албан татвар	124,500.0
1.1.5.	бууны албан татвар	3,240.0
1.1.6.	улсын тэмдэгтийн хураамж	14,000.0
1.1.7.	агнуурын нөөц ашигласны төлбөр, ан амьтан агнах, барих зөвшөөрлийн хураамж	
1.1.8.	байгалийн ургамал ашигласны төлбөр	
1.1.9.	ойгоос хэрэглээний мод түлээ бэлтгэж ашигласны төлбөр	
1.1.10.	түгээмэл тархацтай ашигт малтмал ашигласны төлбөр	
1.1.11.	хүн амын хэрэглээний зориулалтаар ус, рашаан ашигласны төлбөр	
1.1.12.	орлогыг нь тухай бүр тодорхойлох боломжгүй ажил, үйлчилгээ хувиараа эрхлэгч хувь хүний орлогын албан татвар	
1.1.13.	нохойны албан татвар	
1.1.14.	хог хаягдлын үйлчилгээний хураамж	120,000.0
1.1.15.	Газрын төлбөрийн орлого	170,365.8

02000147

D/Khuraldaan/13-р хуралдаан

1.1.16	ҮХЭХ-ийн албан татвар	70,000.0
1.1.17	Цалин хөлс ТАОАТ	4,417,122.6
	Татварын буцаан олголт	-496,000.0
1.2.	Сумын төсвийн татварын бус орлого	256,000.0
1.2.1	Орон нутгийн өмчит болон орон нутгийн өмчийн оролцоотой хуулийн этгээдийн орон нутгийн өмчид ногдох хувьцааны ногдол ашиг	
1.2.2	Түрээсийн орлого	6,000.0
1.2.3	Төсөвт байгууллагын өөрийн орлого	
1.2.4	Хүү, торгуулийн орлого	250,000.0
1.2.5	Нэр заагдаагүй орлого	
	Нийт дүн	5,278,728.4

2.. Сумын 2023 оны төсвийн жилд зарцуулах зарлагын нийт хэмжээг 6,622,054.1 мянган төгрөгөөр баталж, төсвийн ерөнхийлөн захирагч, тэдгээрийн харьяа байгууллагад дор дурдсан төсөв зарцуулах эрхийг олгосугай:

/Мянган төгрөгөөр/

д/д	Төсвийн захирагч	Зардлын дүн /мянган төгрөг/
2.1.	Иргэдийн Төлөөлөгчдийн Хурлын дарга урсгал зардал хөрөнгийн зардал	192,287.4
	Иргэдийн төлөөлөгчдийн Хурлын нарийн бичгийн дарга урсгал зардал, үүнээс: (нутгийн өөрөө удирдах ёсны байгууллага)	192,287.4
	Хөтөлбөр 1: (үндсэн үйл ажиллагааны зардал)	152,190.9
	Хөтөлбөр2: (мэдээлэл сурталчилгааны зардал)	0
2.1.1.	Хөтөлбөр 3: (ажил олгогчоос олгох тэтгэмж, урамшуулал дэмжлэгийн зардал)	2,300.0
	Хөтөлбөр 4: (Багийн ИНХ-ын даргын урамшуулал)	31,796.5
	Хөтөлбөр 5: (гэмт хэргээс урьдчилан сэргийлэх)	6,000.0
2.2.	Засаг дарга Урсгал зардал Хөрөнгийн зардал	5,600,141.6
	Засаг даргын Тамгын газар урсгал зардал	2,375,715.9
2.2.1.	Засаг даргын Тамгын газар урсгал зардал, үүнээс: (орон нутгийн гүйцэтгэх засаглалын удирдлага)	2,375,715.9
	Хөтөлбөр 1: (Үндсэн үйл ажиллагааны зардал)	734,732.8
	Хөтөлбөр 2: (Гэрээгээр гүйцэтгэх ажил үйлчилгээний зардал)	46,575.0

		Хөтөлбөр 3 (Баг хорооны үйл ажиллагааны зардал)	523,643.5
		Хөтөлбөр 4: (ажил олгогчоос олгох тэтгэмж, урамшуулал дэмжлэгийн зардал)	36,184.7
		Хөтөлбөр 5: (Төсөл хөтөлбөр арга хэмжээний зардал)	362,580.0
		Хөтөлбөр 6: (орон нутгийн нөөц сан)	15,000.0
		Хөтөлбөр 7: (Байгаль орчныг хамгаалах нөхөн сэргээх зардал)	2,000.0
		Хөтөлбөр 8: (Баяр наадмын зардал)	5,000.0
		Хөтөлбөр 9: (Урьд оны шилжих үлдэгдэл)	650,000.0
	2.2.2.	Засаг даргын шууд харьяаны байгууллага: ХТГазар урсгал зардал, үүнээс: хөтөлбөр1: Нийтийн эзэмшлийн гудамж талбайн, цэвэрлэгээ үйлчилгээ	1,128,244.7
		хөтөлбөр2: Хур, хог хаягдал орчны цэвэрлэгээ үйлчилгээ	702,744.7
		хөтөлбөр3: Нийтийн эзэмшлийн гудамж талбайн гэрэлтүүлэг	180,000.0
		Хөтөлбөр3: Нийтийн эзэмшлийн гудамж талбайн гэрэлтүүлэг	245,500.0
	2.2.3	Засаг даргын шууд харьяаны байгууллага: ЕБСургуулийн тогтмол зардал, үүнээс: Хөтөлбөр 1: Тогтмол зардлаас санхүүжих дүн	1,332,928.5
	2.2.4	Засаг даргын шууд харьяаны байгууллага: СӨБоловсролын тогтмол зардал, үүнээс: Хөтөлбөр 2: Тогтмол зардлаас санхүүжих дүн	665,358.6
	2.2.5	Засаг даргын шууд харьяаны байгууллага: Соёлын төв зардал, үүнээс: Хөтөлбөр 2: Тогтмол зардлаас санхүүжих дүн	97,893.9
2.3.	2.3.1	Орон нутгийн хөгжлийн сангаас санхүүжих, үүнээс: Хөтөлбөр 1: Орон нутгийн хөгжлийн сангаас санхүүжих дүн	693,325.7
		Орон нутгийн хөгжлийн сангаас олгох орлогын шилжүүлэг, үүнээс: Хөтөлбөр 1: Орон нутгийн хөгжлийн сангаас олгох орлогын шилжүүлэг	625,137.0
		Хөтөлбөр 2: (Урьд оны шилжих үлдэгдэл)	68,188.7

3. Сумын 2023 оны төсвийн жилд сум, дүүргийн төсвийн хөрөнгөөр хэрэгжүүлэх хөрөнгө оруулалтын төсөл, арга хэмжээний зардлын хэмжээг 937,580.0 мянган төгрөг, орон нутгийн хөгжлийн сангийн эх үүсвэрээр хэрэгжүүлэх хөрөнгө оруулалтын төсөл, арга хэмжээний зардлын хэмжээг 693,325.7 мянган төгрөгөөр баталсугай.

4. Сумын 2023 төсвийн жилд аймгийн төсөвт төвлөрүүлэх санхүүгийн дэмжлэг 136,299.3 мянган төгрөгөөр баталсугай.

5. Сумын 2023 оны төсвийн санхүүжүүлэх эх үүсвэрийг 6,622,054.1 мянган төгрөг буюу дор дурдсанаар баталсугай:

5.1. Сумын татварын болон татварын бус орлого 5,278,728.4 мянган төгрөг

5.2. Сумын төсөвт Аймгийн Орон нутгийн хөгжлийн сангаас сумын орон нутгийн хөгжлийн санд олгох орлогын шилжүүлгийг 625,137.0 мянган төгрөг, шилжих үлдэгдлийг 68,188.7 мянган төгрөг

5.3. Сумын төсвийн урьд оны үлдэгдэл 650,000.0 мянган төгрөг

6. “Сумын төсвийн захирагч нарын хэрэгжүүлэх хөтөлбөр, хүрэх үр дүнгийн талаарх чанарын болон тоон хэмжээний үзүүлэлт”-ийг Нэгдүгээр хавсралтаар баталсугай.

7. Сумын шилжих үлдэгдэл болон нэмж тооцсон орлогоос санхүүжих хөтөлбөр, төсөл арга хэмжээний жагсаалт-ыг Хоёрдугаар хавсралтаар баталсугай.

8. “Сумын Орон нутгийн хөгжлийн сангийн 2023 оны хуваарилалт”-ыг Гуравдугаар хавсралтаар баталсугай.

9. Байгаль орчныг хамгаалах, нөхөн сэргээх арга хэмжээний жагсаалтыг Дөрөвдүгээр хавсралтаар баталсугай.

10. Сумын 2023 оны төсвийн хэрэгжилтийг хангах зорилгоор дараах арга хэмжээг авч хэрэгжүүлэхийг сумын Засаг дарга Ч.Сарангэрэлд Үүрэг болгосугай:

10.1. Оны эхнээс төсвийн орлогын төлөвлөгөөг сар, улирал бүр жигд ханган биелүүлж, төсвийн гүйцэтгэлийн болон төсөл хөтөлбөр, хөрөнгө оруулалтын ажлын гүйцэтгэлд тавих дотоод хяналтыг эрчимжүүлж, гүйцэтгэлийн хэрэгжилтийг олон нийтэд сурталчлан таниулах, мэдээллийн ил тод байдлыг ханган ажиллах.

10.2. Төсвийн бүх шатны байгууллагуудад төсвийн урсгал зардлыг оны эхнээс жигд хуваарилж, төсвийн өр, төлбөр үүсгэхгүй байх нөхцөлийг хангаж ажиллах.

11. Тогтоолын хэрэгжилтэд хяналт тавьж, дүгнэлт өгч ажиллахыг сумын иргэдийн Төлөөлөгчдийн Хурлын Төсөв санхүү, Эдийн засаг, төсөл хөтөлбөр хариуцсан хороонд даалгасугай

ДАРГА



Г.МӨНХБАДРАЛ